



**ГОВЬСУМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 08 өдөр

Дугаар A/180

Шивээговь сум

**Газар эзэмших эрхийг шилжүүлэх  
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 30 дугаар зүйлийн 30.1, 38 дугаар зүйлийн 38.4, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаал “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 5.4.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1. Боржигин овогт Дашийн Отгонжаргал /ЗЕ80051504/ нь Шивээговь сумын 1-р баг, 12 дугаар байрны баруун талд байрлах “Автомашины гараж”-ийн зориулалттай 21м<sup>2</sup> газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул иргэн Боржигин овогт Мөнхжаргалын Гантөмөр /ЕУ95010914/-д Шивээговь сумын 1-р баг, 12 дугаар байрны зүүн талд байрлах 21м<sup>2</sup> газрыг “Автомашины гараж”-ийн зориулалтаар эзэмших эрхийг 15 жилийн хугацаагаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн (М.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн М.Гантөмөртэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг сумын Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/181 дугаар захирамжийн 8 дахь бүртгэлийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

Ч.СУГАРМАА